ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2025 он)
УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 1. УХТЭ-ийн 2025 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалт-15<br>2. Эрдэм шинжилгээний хурал-2<br>3. Багц цагийн сургалт-28<br>4. Шинэ ажилтны чиглүүлэх сургал-1<br>5. Эмч нарын яриа-38 | 100% | Тайлангийн жилд 590 эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид 84 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт ажилтан хамрагдаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн. Эмч нарын яриа, төгсөлтийн дараах эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалт (багц цагийн сургалт), УХТЭ-ийн 2025 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан болон цахим сургалт, өдөрлөг, зөвлөгөөн, уулзалт, Эрдэм шинжилгээний хуралд тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан.<br>2025 онд зохион байгуулагдсан 38 удаагийн эмч нарын рианд давхардсан тоогоор 2030 удаа эмч нар ирцээ бүртгүүлсэн байна:<br> |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үнээс | Ажлын байран дахь сургалт | 12 | 100% | УХТЭ давхардсан тоогоор 590 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд доорх сэвэв бүхий 12 удаагийн ажлын байрны сургалтад хамрагдсан байна.<br><br>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал<br>2. Галын аюулгүй байдал<br>3. Амилуулах суурь тусламжийг хөх кодоор үзүүлэх нь<br>4. Төрийн байгууллагын мэдээллийн систем ERP ашиглалт<br>5. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хууль эрх зүйн сургалт<br>6. Хувь хүний бүтээмж, харилцаа хандлагын сургалт<br>7. Шинэ ажилтны чиглүүлэх сургалт<br>8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын сургалт<br>9. Олон эмэнд тэсвэртэй бичил биет<br>10. МТСА-ын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлт хяналт<br>11. Оюуны өмчийн тухай ойлголт<br>12. Эрүүл мэндийн салбарын шинэ технологи, хиймэл оюун ухаан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Мэргэшүүлэх сургалт | 3 | 66.6% | 2025 онд улсын төсвийн санхүүжилтээр, байгууллагын зардлаар суралцуулах эмч, эмнэлгийн мэргэжилтний захиалгыг хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан хязгаарын дагуу эмч мэргэжилтнүүдийг мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцуулж байна.<br>Тайлангийн жилд үндсэн мэргэшлийн сургалтад-0<br>**Тайлбар:** 3 дугаар шатлалын эмнэлэгт үндсэн мэргэшлийн сургалт буюу резидентийн сургалтандаа хамрагдсан, нарийн мэргэшлийн эмч ажилладаг учир төрийн сан болон байгууллагын зардлаар үндсэн мэргэшлийн сургалтад эмч нарыг сургах хэрэгцээ байдаггүй.<br>Тайлангийн жилд төрөлжсөн мэргэшлийн сургалтад-0<br>**Тайлбар:** Эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2 эмчийг сургах захиалгыг өгсөн ч ЭМХТ хүсэлтийг татгалзсан.<br>Тайлангийн жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад-2<br>**Тайлбар:** Захиалгын дагуу Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, Гемодиализ судлал мэргэжил дээшлүүлэх сургалтад тус бүр 1 эмчийг төрийн сангийн зардлаар сургасан.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт 1 удирдах ажилтан, 29.1-р зүйлд “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна” гэж заасны дагуу Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 12 мэргэжилтэнг, “ажлаасаа хөндийрөлгүйгээр “зайн сургалтад хамруулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 2 | 100% | УХТЭ болон УНТЭ-ийн хамтын ажиллагааны хүрээнд Бөөр шилжүүлэн суулгах багийн 25 эмч, сувилагч, Эрхтэн шилжүүлэн суулгах багийн 15 эмч, сувилач нийт 40 ажилтныг УНТЭ-т туршлага солилцон, мэргэшүүлэх сургалтад хамруулллаа. |
| | | | Бусад | 6 | 100% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн дагуу Дотрын анагаах судлал, Яаралтай тусламж судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчилгээ судлал, Дүрс оношилгоо судлал, Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлалаар суралцагч нарыг УНТЭ, УГТЭ, НӨАГ, ХСҮТ, ХӨСҮГ, СЭМҮТ, НААГ, ГССҮТ, ЭХЭМҮТ-д сургалтын тойролт хийлгэсэн. |
| | | 1.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 590 | 100% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Яаралтай тусламжийн үеийн “Амилуулах суурь тусламж” сургалтад нийт ажилчдийг бүрэн хамруулсан. |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 165 | 28% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Яаралтай тусламжийн үеийн “Амилуулах суурь тусламж” сургалтад нийт ажилчдийг бүрэн хамруулсан. |
| | | | Эрэгтэй албан хаагч | 425 | 72% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Яаралтай тусламжийн үеийн “Амилуулах суурь тусламж” сургалтад нийт ажилчдийг бүрэн хамруулсан. |
| | | | Удирдах албан тушаалтан | 4 | 0.6% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Яаралтай тусламжийн үеийн “Амилуулах суурь тусламж” сургалтад нийт ажилчдийг бүрэн хамруулсан. |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 52 | 8.8% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Яаралтай тусламжийн үеийн “Амилуулах суурь тусламж” сургалтад нийт ажилчдийг бүрэн хамруулсан. |
| | | 1.3. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад | 590 | 100% | Мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 2025 оны хүний нөөцийн сургалтын төлөвлөлтийн дагуу 100% хэрэгжсэн бол байгууллагуудын дотоод сургалт, зайн сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулан ажилласан. |
| | | | эзлэх хувь | | | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтнүүд HRDS (hdc.gov.mn) программаар хүсэлт илгээж багц цагийн сургалтад хамрагдан багц цагаа бүрдүүлсэн. |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1. | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 7 | 100% | Япон улсад нэг сарын хугацаатай туршлага судлуулах “Илгээлтийн эзэд” хөтөлбөр хэрэгжсэн. Энэхүү хөтөлбөрт нийт 23 ажилтан хамрагдсан.<br>Амьд донороос бөөр шилжүүлэн суулгах ажлын хүрээнд НЛТ-ын их эмч Ш.Болортуяа болон БДШТ-ын их эмч М.Болортуяа нар Тайван улсын Тайваны их сургуулийн эмнэлэгт нэг сарын сургалтад хамрагдсан.<br>ЯТТ-ын их эмч Х.Батхүү Солонгос улсын Pusan National University Yangsan Hospital-д 1 сарын хугацаатай сургалтад хамрагдав. /2025.06.29-2025.07.25/<br>ЯТТ-ын их эмч Энэбиш, Одончимэг, НЭМ-ийн мэргэжилтан Гүнчинхорлоо, Хүүхдийн тасгийн ахлах сувилагч Номин-Эрдэнэ нар Энэтхэг улсад 1 сарын хугацаатай сургалтад хамрагдав.<br>Гэмтэл согог, сэргээн засах мэс заслын тасгийн эрхлэгч Г.Билгүүн Seoul National University Hospital-д 5 сарын сургалтад хамрагдлаа.<br>Цахим эмнэлгийн туршлага судлах зорилгоор эмнэлгийн захиргаа, мэдээллийн технологийн албаны дарга, эмчийн төлөөлөл гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг БНХАУ Шанхай |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 30 | 100% | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 26 | 100% | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 4 | 100% | |
| | | | Удирдах албан тушаалтан | 2 | 100% | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 28 | 100% | |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | | 5.3% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хотод очин туршлага судлав.<br>НЛТ-ын лаборант Г.Доржханд, БДШТ-ын их эмч Ж.Одгэрэл нар Тайвань улсад 1 сарын ажлын байран дахь сургалтад хамрагдлаа. /2025.08.04-2025.08.29/ |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 10 | 80 % | Төрийн зардлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаачдын үндсэн цалинг Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтаар 5 жил тутамд мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 56/97 дугаар хамтарсан тушаалын дагуу 3 хүртэлх сарын үндсэн цалин, замын зардал болох 19,800,303 / арван есөн сая найман зуун мянга гурван зуун гурван мянга/ үндсэн байгууллагаас гэрээний дагуу төлж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | | 1. Хөдөлмөрийн харилцаа цуцалсан-131<br>2.Ажилд орсон-72<br>● сул орон тоо-11<br>● Түр орон тоо-7<br>● Жирэмсний амралтаас эргэн ажилдаа орсон-4<br>● Сэлгэн-1<br>3.Дотоод шилжилт-37 | 1. 22 %<br>2. 12 %<br>● 1.9 %<br>● 1.2 %<br>● 0.6 %<br>● 0.1 %<br>3. 6.2 % | Эмнэлгийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 17 өдрийн А/74 тушаалын 2 дугаар хавсралтаар эмнэлгийн орон тоо, байршуулалтыг 674 хүний орон тоотой баталснаас 2025 оны 12 дугаар сарын 30 байдлаар 590 хүний бүтэц орон тоотойгоор ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/446 дугаар тушаалаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн бүтэц дүрэм, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | Цалин 22.776.4 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 44% | Урамшуулал 2.426.1сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 8% | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5, 25, 395, 276,<br>2018 оны 382 дугаар 2022 оны 107 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллаж байна.Биелэлт нь 98%.-тай байна. |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл 1.287.329.2 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 5%.. | . | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 дугаар тушаалаар тогтоож өгсөн эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаар 2025 онд 1.287.329.2 сая төгрөг зарцуулж, нийт төсвийн 5%- ийг эзэлж байна. Биелэлт нь 100% байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 100% | 100% | Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 2024 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгээс дахин боловсруулсан асуумжийн дагуу Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн асуумж нь 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авсан. 2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар “Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 447 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан байна.<br>Эмнэлгийн ажилтны ерөнхий сэтгэл ханамжийн хувь 52.6% (маш сайн, сайн) байна. 2025 оны 1,2,3,4 дүгээр улирлын байдлаар графикаар харьцуулбал: |




Эмнэлгийн ажилтны ерөнхий сэтгэл ханамжийн хувийг 2022,2023,2024,2025 онтой харьцуулсан графикаар харьцуулбал:




Судалгааны үр дүнг шийдвэр гаралт, төлөвлөлтөд ашиглаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар үйлчилгээ үзүүлэгчдэд тухай бүрт мэдээлж байв.

2026 оны 1 дүгээр улирлын байдлаар “Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 97 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан. Ерөнхий сэтгэл ханамжийн хувь 58.4% (маш сайн, сайн) байна.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 90% | 95.08% | УХТЭ-ийн ажилтнуудын урдчилан сэргийлэх үзлэгийг 2025 оны 04-р сарын 01-наас 2025 оны 10-р сарын 01-ны хооронд зохион байгуулагдсан. Нийт 590 ажилтнаас 561 ажилтан үзлэгт хамрагдаж, үзлэгийн хамрагдалт 95.08% байна. Ажилтнуудын дунд 13 бүлгийн 88 гаруй эмгэг байгаагаас дараах эрхтэн тогтолцооны өвчлөлүүд байна. Эрүүл мэндийн салбарын ажилчдыг хуваарийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. 2025 онд шинээр В гепатит 1 илэрсэн. УХТЭ-ийн Хүүхдийн тасаг, Халдвар хяналтын алба хамтран Гепатит В вирусийн эсрэг тарилгыг нийт 232 хүн/тун, Томуугийн эсрэг тарилгыг 323 хүн/тун, ХПВ-ийн эсрэг тарилгыг 217 хүн/тун, Улаанбурхан улаануудын эсрэг тарилгыг 300 хүн/тун тус бүр дархлаажуулалт хийгдсэн. Тайлангийн жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 63 эрүүл мэндийн ажилтан хэвтэн эмчлүүлсэн. Мөн нийт үзлэгт хамрагдсан ажилтнуудын 20% орчим нь хяналтанд байх 3% орчим нь онош тодруулах шаардлагатай байсан. |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 90% | 95.08% | Нийт албан хаагчдын 95.08% нь эрүүл мэндийн үзлэгт 561 ажилтан хамрагдсан байна. |
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ 19.800.000/ арван есөн сая найман зуун мянган төгрөг/ | Төлөвлөлтийн дагуу | Тайлант оны гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн байгууллагууд Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулан ажилтны нийгмийн баталгааны чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5 дугаар заалтаар зүйлийн дагуу 9 эмнэлгийн мэргэжилтэнд 19,800,000 төгрөг зарцуулсан.. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ажилласан нийт эрүүл мэндийн ажилтнуудын 95 % хамрагдсан. |

ХЯНАСАН: ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР Б.ЖАВХАА

НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР П.УЯНГАСАЙХАН